



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 5/3

Хэрлэн сум

Л.Энэбишийг ажилд түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4, 23 дугаар зүйлийн 23.2.3, 24 дүгээр зүйлийн 24.1, 26 дугаар зүйлийн 26.1, 112 дугаар зүйлийн 112.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.16, Засгийн газрын 2007 оны Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай 354, 2014 оны Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авилгатай тэмцэх газрын 2018 оны 05/35 тоот албан бичгийн дагуу Л.Энэбишийг 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Солонгын жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаанд түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Сургуулийн захирлын түр орлон гүйцэтгэгчээр томилогдож байгаа Л.Энэбишийн цалинг ТҮБД-7-1 шатлал 673849 /зургаан зуун далан гурван мянга найман зуун дөчин есөн/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг сургуулийн нягтлан бодогч /Л.Алтанцэцэг/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА